

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн
2014 оны 55 дугаар тогтоолоор баталсан
“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах,
гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ын
хяналт-шинжилгээ

2024 оны 03 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Нэг. Журмын зүйл, заалтын талаар

“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ыг нийслэлийн өмчийг эзэмшигч байгууллагаас нийслэлийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, хөрөнгийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу данс бүртгэлд тусгах, Өмчийн харилцааны газар, холбогдох бусад байгууллагаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, нийслэлийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар гэрээ байгуулах, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэхэд дагаж мөрдөхөөр батлагдсан бөгөөд хэрэгжиж эхлээд 10 жил болсон байна. Журамд 5 зүйлийн 15 заалт, 5 хэсэг туссанаас:

Нэг. Нийтлэг үндэслэл – 2 заалт
Хоёр. Гэрээ байгуулах – 2 заалт
Гурав. Гэрээний биелэлтийг дүгнэх – 6 заалт, 5 хэсэг
Дөрөв. Гэрээний биелэлтийг дүгнэх аргачлал – 3 заалт
Тав. Бусад зүйл - 2 заалт

Хоёр: Хэрэгжилтийн талаар

Нийслэлийн Өмчийн харилцааны газар нь журмын 2.1-д заасны дагуу нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээг нийслэлийн өмчит төсөвт **818** байгууллагын удирдлагатай байгуулсан, 3.1-д заасны дагуу газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулан жил бүр гэрээний биелэлтийг дүгнэн дүнг нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулан ажилласан байна.

“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ын нийт 15 заалтыг бүрэн хэрэгжүүлдэг байна.

Гурав.Дүгнэлт

“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг дүгнэх журам”-ыг хэрэгжүүлснээр нийслэлийн өмчийн хөрөнгийг нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагад гэрээгээр эзэмшүүлэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт сайжирч, төсвийн мөнгөн хөрөнгийн зарцуулж, эзэмшил газрыг зориулалтын дагуу ашиглан, хөрөнгийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу зохион байгуулж байна.

Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй, нийслэлийн өмчид тавих хяналтыг сулруулж, үрэгдүүлэх нөхцөл бүрдүүлсэн, зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн, данс бүртгэлээс хассан, хандивласан, барьцаалсан, түрээслүүлсэн байгууллагын удирдлагад хариуцлага тооцох асуудлыг тус журамд тусгасан байна.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал

Нийслэлийн төсөвт байгууллагын удирдлагуудтай “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулан байгууллагын санхүүгийн тайлан тэнцэлд тусган эд хөрөнгийг хүлээлгэн өгснөөр өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх,

илүүдэлтэй байр талбайг иргэд, хуулийн этгээдэд холбогдох журмын дагуу түрээсийн гэрээгээр эзэмшүүлэн түрээсийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу явуулах зэрэг харилцааг зохицуулдаг тул зайлшгүй шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

“Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ”-ээр үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллагууд нь баланст бүртгэлтэй, үнэ төлбөргүй эзэмшдэг нийслэлийн өмчийн барилгыг зориулалтын бусаар ашиглах, бусдад зөвшөөрөлгүй түрээслүүлэх, барилгын хийц загварт өөрчлөлт оруулах зэрэг холбогдох хууль, дүрэм журам зөрчил гарч байгаа тул НӨХГ-аас гэрээг дангаараа цуцлах, хариуцлага тооцох асуудлыг журамд оруулах саналтай байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд (ӨЭМТ) нь нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан бөгөөд өмч хөрөнгө нь гишүүдийн хөрөнгө, хувийн өмчийн эд хөрөнгөөс бүрддэг байна. “Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ” байгуулан ӨЭМТ-ийн баланст нийслэлийн өмчийн барилга байгууламж, тээврийн хэрэгсэл бусад хөрөнгийг бүртгэсэн нь холбогдох хууль дүрэмд нийцэхийг тодруулах санал оруулж байна.